



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/159

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 45, 104 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 15 дугаар хурлын шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2021 оны 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00.00 цагаас 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06.00 цаг хүртэл сунгасугай.

2. Коронавируст (КОВИД-19)-ын өвчлөл батлагдсантай холбогдуулан аймаг, сумдаас орох гарах хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Дээрх хугацаанд үйл ажиллагааг хязгаарлахгүй тусгай горимоор ажиллуулах байгууллагуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

4. Дээрх хугацаанд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааг хязгаарласугай.

5. Хүнсний дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 21.00 цагийн хооронд байхаар тогтоож, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт даалгасугай.

6. Бараа, барилгын материалын худалдаа, үсчин гоо сайхан, халуун ус, автозасвар, сэлбэг, хими цэвэрлэгээ, утас засвар, гутал засварын ажиллах цагийн хуваарийг 10.00 цагаас 17.00 цагийн хооронд байхаар тогтоож, халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт даалгасугай.

7. Архи, согтууруулах ундааны зүйлс худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглож хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт даалгасугай.

8. Дээрх хугацаанд албан байгууллага, аж ахуйн нэгж, орон сууцны орц, хүүхдийн тоглоомын талбай зэрэг халдвар тархах эрсдэл бүхий орчны ариутгал халдваргүйтгэл хийж гүйцэтгэх хуваарийг батлуулж ажиллахыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагууд, халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

9. Уул уурхайн компаниудын ажилчдын ээлж солих ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хязгаарлаж, тээвэрлэлтийг батлагдсан маршрутын дагуу халдвар хамгааллын дэглэмийг баримтлуулан гүйцэтгүүлж хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн

481210441

газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

10. Оршуулга, буяны ажиллагаанд оролцсон иргэдээс халдвар тархах эрсдэл өндөр байгаа тул оролцох хүний тоонд хязгаарлалт тогтоож зохион байгуулах талаар иргэдэд заавар, зөвлөмж өгч хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар)-т үүрэг болгосугай.

11. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж, зайлшгүй шаардлагаар голомтын бүс нутгаас нэвтэрч байгаа болон Өмнеговь аймгаас ирж буй иргэдийн PCR шинжилгээний хариуг сайтар нягтлан шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж, тусгаарлан ажиглах байранд авч 7 хоног хяналт тавьж, шинжилгээний дүнг үндэслэн гэрийн ажиглалтад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

12. Хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аймгийн Онцгой комиссын зөвшөөрлөөр хязгаарлаж, дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг зогсоохгүй өнгөрүүлэхээр зохицуулсугай.

13. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хууль тогтоомжийг мөрдөж, онцын шаардлагагүй бол гэрээсээ гарахгүй байж, мэргэжлийн байгууллагуудын зөвлөмжийг хэрэгжүүлэн, халдвар, хамгааллын дэглэмийг баримтлахыг аймгийн нийт иргэдэд уриалсугай.

14. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ